


Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын нөлөөгөөр манай говь хээрийн бүс нутагт хур тунадасны хэмжээ эрс багасаж, цөлжилт эрчимжсэн нь байгаль экологид болон орон нутгийн нийгэм эдийн засагт ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн хүний буруутай үйл ажиллагаа, техник-технологийн үсрэнгүй хөгжил эргээд байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулсаар байна.



Манай аймаг газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, газар нутгийн гадаргын хэв шинж, экологийн тогтолцооны хувьд нэн эмзэг хуурай тал хээр, цөлөрхөг хээрийн бүсэд оршдог, 7469.0 мян,га нутаг дэвсгэртэй. Үүний 7128.0 мян,га буюу 95.4% нь бэлчээрийн газар эзэлдэг байна.

Аймгийн нийт хүн амын 70 орчим хувь нь дан ганц мал аж ахуйн орлогоор амьдардаг малчин, мал бүхий иргэд юм.

Уур амьсгалын төлөв байдал

Агаарын температурыг олон жилийн дундажтай харьцуулбал 2014 оны 11 дүгээр сар, 2015 оны 1 дүгээр сард ихэнх нутагт дунджаас 1.1-7.3 градусаар дулаан харин 2014 оны 12 дугаар сар, 2015 оны 12 дугаар сард нутгийн баруун болон баруун өмнөд хэсгээр дунджаас 1.1-5.0 хүйтэн, зүүн өмнөд хэсгээр дунджаас 1.1-3.6 °C дулаан бусад нутагт дунджийн орчим байлаа.

Хур тунадас 2014 оны 11, 12 дугаар сард ихэнх нутгаар 0-5 мм, 11 дүгээр сард аймгийн нийт нутгаар 1-3 мм их орсон газартаа 3 мм байлаа. 2015 гараад 1, 2 дугаар сард ихэнх нутгаар 0.0-3.0 мм ба олон жилийн дунджийн орчим ба түүнээс бага, 2 дугаар сард 50 гаруй хувьд дунджийн орчим ба түүнээс бага, харин 11,12 сард ихэнхи нутгаар 4-7 мм, сард орсон тунадасны хэмжээг олон жилийн дундажтай харьцуулбал ахиу байсан.


2014 оны 12 дүгээр сарын эхээр нийт нутгийн 50 орчим хувьд цастай байсан боловч дулаан байснаас цастай нутгийн хэмжээ багасч 11 дүгээр сарын сүүлч гэхэд 30 гаруй хувь болж буурсан. Үүнээс цааш цастай нутгийн хэмжээ болон цасны зузаан нэмэгдэж 2015 оны 1 дүгээр сарын 31-ний гэхэд нийт цас хайлж багассан.

2014-2015 оны өвөл зарим газруудад зузаан, нягтарч хатуурсан цастай байсан боловч дулаан байж, мал өвөлжилтөнд тааламжтай байлаа. Харин 2015-2016 оны өвөл хүндрэх төлөвтэй болж 12 дугаарын сарын дунд үеэс сар дуустал 7 удаагийн тохиолдлоор 3.3-8.0 мм цас орж олон жилийн дундажаас ахиу хур тунадастай байлаа

2015 оны 12 дугаар сард агаарын дундаж температур нийт нутгаар 14.1...19.3 градус хүйтэн байсан нь олон жилийн дундажтай харьцуулахад Дэлгэрхангайд олон жилийн дунджаас 3,5 градусаар дулаан, Мандалговь, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Адаацаг, Дэрэн, Луус сумдад олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар олон жилийн дунджаас 1.1...3.3 градусаар хүйтэн байлаа. Өдөртөө Гурвансайхан, Хулд, Дэлгэрхангайн нутгаар 2...3 градус, бусад нутгаар 4...9 градус хүйтэн, шөнөдөө Сайхан-Овоо, Дэрэн, Эрдэнэдалайд 32...33 градус, Дэлгэрхангайд 23 градус, бусад нутгаар 26...29 градус хүйтэн байжээ. Хөрсний гадарга дээр өдөртөө Мандалговь, Гурвансайхан, Эрдэнэдалай, Өндөршилд 0...4 градус дулаан, бусад нутгаар 2...6 градус хүйтэн, шөнөдөө Адаацаг, Цагаандэлгэрт 34...35 градус, бусад нутгаар 28...33 градус хүйтэн байжээ.


Салхины их хурд нь түр зуур нийт нутгаар 10 - 20 м/с хүрч, 10 м/секунд түүнээс их салхитай өдрийн тоо 2 – 15 удаа ажиглагдсан байна.

2014-2015 оны өвөл, хаврын бэлчээрийн
даац, %(багийн нутгаар)



Хөрсөн бүрхэвч

Манай аймгийн нутаг дэвсгэр хөрс-газарзүйн мужлалтаар нутгийн хойт хэсэг нь Төв Азийн их мужийн Хангайн мужийн өргөрөгийн бүсийн хүрэн хөрсний бүсийн 2-р тойрог, нутгийн өмнөд хэсэг нь Говийн мужийн өргөрөгийн бүсшилийн цайвар хүрэн хөрсний дэд бүсийн 4-р тойрог, цөлөрхөг хээрийн бор хөрсний дэд бүсийн 6-р



тойргуудад тус тус хамрагдана.

Дээрх мужлалтаар авч үзэхэд тус аймгийн нутагт тал хөндийн болон нам уулс, ухаа гүвээ толгодын хүрэн, мараалаг хүрэн, нугат хүрэн, цайвар хүрэн, говийн бор, мараалаг говийн бор, хужир, марз, шал, мараа хөрс голлон тархах уулын хар

хүрэн, хүрэн, цайвар хүрэн болон нуга намгийн, цөлийн бор саарал хөрс өчүүхэн бага талбайд тархана.

Тус аймгийн нутагт голлон тархсан хүрэн хөрс хуурай хээрийн бүсийн өмнөд хэсгээр, эсвэл хархүрэн хөрстэй талархаг нутгийн доторхи уудам хотгоруудад харгана бүхий үетэнт, агь-үетэнт ургамалшилтай газраар тархах бөгөөд ургамал нөмрөгийн бүрхэц нь 30-50% байна. Ялзмаг хуримтлалын А давхаргын зузаан дунджаар 16 см, нийт ялзмагт үеийн (А+В₁) зузаан дунджаар 33 см байна. Хүрэн хөрсөн дэх ялзмагийн хэмжээ 3%-иас бараг хэтрэхгүй, хөнгөн шавранцар хөрсөнд 2-3%, элсэнцэр хөрсөнд 1.5-2% орчим байна. Урвалын орчин карбонатын давхаргаас дээших хэсэгт саармаг буюу түүнтэй ойролцоо, доод давхаргуудад шүлтлэг шинжтэй байна. Шингээх багтаамж их биш, хөнгөн шавранцар хөрсөнд 100 гр-д 12-20 мг-экв, элсэнцэр хөрсөнд 6-12 мг-экв, солилцоот сууриудын бүрэлдэхүүнд кальций эрс давамгайлж, заримдаа натри ион байх боловч хэмжээ нь даан ч бага (100 гр хөрсөнд 1-2 мг-экв) байна.

Цайвар хүрэн хөрс нь цөлөрхөг хээрийн бүсийн хойт хэсэгт үетэн-монгол өвст бүлгэмдэл голлож агь, сонгино, харгана нэлээн холилдсон газраар тархах бөгөөд ургамлын бүрхэц 20-30%-иас үл хэтэрнэ. Хөрсний гадаргын ихэнх хэсэг ургамалгүй цулгүй байдаг учраас салхины үлээгдэлд хялбар өртөж том ширхэгтэй элс, жижиг сайр чулуугаар бүрхэгдсэн байна. Заримдаа халцгай газраар үелсэн бүтэцтэй, нимгэн (0.5-0.6 см), маш хэврэг хальслаг үе тогтсон харагддаг. Ялзмаг хуримтлалын давхарга (А) нь цайвар хүрэн өнгөтэй, бүдэг бөөмөрхөг бүтэцтэй, нилээд тод илэрсэн, зузаан нь дунджаар 10 см байна.

Урвалын орчин хөрсний бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй, ялангуяа доод давхаргуудад илүү шүлтлэг байна. Шингээх чадвар бага (100 гр хөрсөнд 9-15 мг-экв), солилцоот катионуудын найрлагад натри ион тун өчүүхэн хувийг эзэлнэ.

Цөлөрхөг хээрийн /говийн/ бор хөрс ялзмагийн агууламж багатай, түүний хэмжээ хөрсний дээд давхаргуудад 0.4-0.5%-иас 1.3-1.5% хүртэл хэлбэлзэх бөгөөд В_t, В_{Ca} давхаргад ялзмагийн хэмжээ ялимгүй ихсэх хандлагатай байдаг нь ургамлын үндэсний хуваарилалттай холбоотой. Хөрсний урвалын орчин бүх үе давхаргад шүлтлэг шинжтэй (рН 8.1-9.4). Хөрсний шингээх багтаамжийн хэмжээ бага (100 гр хөрсөнд 7-15 мг-экв), солилцоот сууриудын найрлагад кальци ион давамгайлж, заримдаа натри ялимгүй хэмжээтэй.

Ургамал, ургамлан нөмрөг

Дундговь аймгийн нутаг бол Төв Азийн ургамал, ургамалжилтын жинхэнэ төлөөлөл болох хуурай хээр, цөлөрхөг хээрийн ургамалтай. В.И.Грубав(1955), Н.Өлзийхутаг (1986),нарын мэдээгээр энэ бүс нутагт бэлчээр тэжээл, эм, хүнс, гоёл чимэглэлийн зэрэг 400 гаруй зүйлийн гуурст дээд ургамал бүртгэгдсэн. Ургамлан нөмрөг бэлчээрийн хувьд хялгана - харгант, хазаар өвс – хялгант, хиаг – хялгана – хазаар өвст соргог өвст бэлчээр бүхий хуурай хээр зонхилж, хялгана(говийн)-таана – баглуурт, хялгана – хазаар өвст – агьт, хялгана – боролзой – шарилжит, хялгана – харгана, таана – хялганат, таана – улалж, бударгана – шарилжит, дэрс – бударгант, бор шавагт, бударгана – хармагт цөлийн хээр зонхилдог байв. Хужиртай байдам (нуга шавартай) газарт таана- улалж, улалж – зурман сүүлт, ахар сорт арвай – марцны цэгээлж – ширэг улалжит бүлгэмдэл зонхилно. Гэтэл сүүлийн жилүүдэд болж буй ган цөлжилтийн улмаас ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ургамлын нөмрөгт эрс өөрчлөлт оржээ.Тухайбал гантай цөлжсөн Дэлгэрцогт, Дэрэн сумын өмнөд хэсэг, Сайнцагаан, Өндөршил, Гурвансайхан сум бүхэлдээ, Говь-Угтаал, Баянжаргалан, Хулд , Өлзийт сумын ихэнх нутагт бэлчээрийн зонхилох ургамал хялгана, хазаар өвс , хиаг, агь , энэ жил ургаагүй. Харин Дэлгэрцогт, Дэрэн , Говь-Угтаал сумын нутгаар хялгана, дэрс ургах боловч өсөлт муутай. Дэлгэрцогт сумын “Уст хар толгой” гэдэг газарт жижиг навчит хялганы бутны өндөр 40см , бутны 40% цэцэг навчгүй хатсан, бутны иш 30см хүртэл элсэнд дарагдсан. Дэрсний өндөр 30см, дэрсний бутны хоорондын зай 5 – 6м , тэдгээрийн хооронд лууль өндөр нь 1см, Адамсын шарилж – 3см , ганц нэг хиагны навч - 4см, имт гичгэнэ – 1см , таравган шийр – 0.5см үзэгдэнэ. Дэрэн сумын нутагт гантай , хялгана , хазаар өвс , агь ургаагүй байна. Хааяа харгана, дэрс сийрэг ургах ба дэрсний түрүү үүсээгүй. Давстын говьд бор бударгана – 25см улаан бударгана – 30см , түжгэр баглуур , лууль зэл зангуу үзэгдэнэ .Бударганы дунд 5*4м хэмжээтэй таанын толбо (синуз) тохиолдох түүний өндөр 12см хааяа хамхуул үзэгдэнэ.(10см)

Говь-Угтаал сумын нутагт жижиг навчит харгана шигүү, өндөр ургана. Харганы бут хоорондын зай 3 м өндөр 40-50 см. Түүний бүрхэц 30-35 %. Таана 4 см, хөмөл 8 см, харганы бутны засвар ургана, тэдгээрийн бүрхэц 7-10%. Харганы бутны ёроолд элс их хуримтлагдсан байлаа.


Монгол оронд 1950, 1960, 1970 онд явуулсан ургамал, ургамалжилтын судалгаатай харьцуулахад тус аймгийн нутаг дэвсгэрт ургамлын зүйлийн тоо 4 – 5 дахин, ургац 6 дахин багассан. Мэргэжлийн байгууллагаас 1961–1963 ба 1992 онд хийгдсэн судалгаагаар Эрдэнэдалай, Сайхан-Овоо, Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн суманд 1100-1184 га хадланд тохиромжтой талбай байсан бол одоо тийм талбай огт байхгүй болжээ.

Айюүиү аеiаг

Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт, Луус, Дэлгэрхангай, Сайхан-овоо, Хулд, Өлзийт, Өндөршил, Гурвансайхан, Говь-угтаал, Баянжаргалан зэрэг 11 суманд 4810 км² нутагт аргаль, янгир байна. Сумдаар нь авч үзэхэд Адаацагт 26 аргаль хонь, 3 янгир ямаа, Өлзийт суманд 59 аргаль хонь, 27 янгир ямаа, Баянжаргаланд 88 яргаль хонь, 24 янгир, ямаа, Дэлгэрцогт 25 аргаль хонь, 3 янгир ямаа, Гурвансайханд 12 аргаль хонь, 19 янгир ямаа ажиглаж харснаас үзэхэд аймгийн нутаг дэвсгэрт харилцан адилгүй тархан байршиж байна.

Дундговь аймгийн аргаль янгирын тархац нутаг нь Адаацаг сумын Адаацаг уул, Ар урт Бэрхийн уулнаас Дэлгэр цогт сумын бага газрын чулуу дэлгэрэх , хатуугийн уулын хооронд Дэлгэрхангай сумын Дэлгэрэх уул-Хул, Тээг, Сайхан овоогийн Цогт, Ахарын уулын хооронд Хулд сумын Хулдаас Талын богд, Уушиг, Тээг, Сэнжий, Өөш манхан хүртэл Өлзийтийн Хананхэц, Баянхайрхан, Хул,Тээг, Хүрэн хавтгай, Хавтгай, Талын богд Бага бууралын хооронд Уул хадарганатаас хойш Гурвансайхан уул, Баян улаан уул, Их газрын чулуу, Бичигт, Арагийн хад хүртэл шилжилт хөдөлгөөн хийж болохыг газарзүйн байршил хоорондын зай ус, бэлчээр, хуучин байсан дэлгэц нутаг, зам харгуй, уул уурхайн байршил хүн малын суурьшил нүүдэл, нутгийн иргэдийн ам мэдээлэл, өөрсдийн судалгааны арга зүй зэрэгт анализ хийж тогтоов.

Дундговь аймгийн 7469 мянган км² дэвсгэр нутгийн 5240 км² буюу 7.0%-д нь аргаль хонь, янгир ямаа бүхий агнуурын амьтдын тархац нутаг эзэлж байна. Дундговь аймгийн 9 суманд нийт 1227 км² талбай бүхий 10 хэсэг газарт шинээр агнуурын бүс нутаг тогтоож энд нийт 24 сүргийн 256 бодгаль, янгир ямааны нийт 8 сүргийн 172 бодгаль бүртгэж нөөцийн үнэлгээ тогтооход 422 аргаль хонь, 306 янгирямаа 1000 га-д 0.4 бодгаль нягтшилтай байршин амьдарч байна.



Цагаан зээр

Тус аймгийн нутагт хийгдсэн судалгааны ажил, аман мэдээний дүнгээс үзвэл намрын сүүл, өвлийн эхэн улиралд 5000-7000 мянган толгой цагаан зээр тархан байрших бололцоо байна. Аймгийн хойд хэсгийн 8 сумын нутгийг хамарсан 15600 км² орчим тархац нутагт 3400 орчим цагаан зээрийн нөөц тогтоогдлоо

Хар сүүлтий (*Gazella subgutturosa*)- н тархац, байршилт, тоо толгой
 Өлзийт сумын урд хэсэг говийн бүсэд /Дэлийнбулаг,Цагаансуврага/ 1-5 бодгалиар сүрэглэн 30-40 толгой хар сүүлтий тархан байршиж байна.



Монгол тарвага(*Marmota sibirica*)-ны тархац, байршил, тоо толгой

Тарвага тус аймгийн нийт нутагт 2000 оноос өмнө элбэг тархацтай(1000 га-д 42 бүл) байсан боловч ган, зудны улмаас 2000 оноос

эрс ховордож одоогийн байдлаар зөвхөн Эрдэнэдалай сумын Цонж уулд нэг бүл, Говьугтаал сумын Бичигтийн хад орчимд 3 бүл тарвага, Дэлгэрцогт сумын Бага газрын чулуунд 40 гаруй бүлд 130 орчим тарвага бусад тархац нутагт тарвага ажиглагдаж тэмдэглэгдээгүй юм. Дээрхи хэдэн цэг нь голомтоос бусад газар тарвага устсан байна. Тарваганы нөөцийг 300 орчим гэж тогтоов.

Мануул мий (*Felis manul*)-ийн тархац, байршил тоо толгой

Дунговь аймгийн урд сумдаас бусад сумдын нутагт тархсан. Орон нутгийн иргэдээс авсан аман судалгааны дүн мануулмий тархац, тоо толгой бага ховордсон болохыг харуулж байна. Аймгийн хээр, хад чулуут бэсрэг уулс, өндөр уулархаг нутгаас 3100 орчмыг агнаж улсад тушаадаг байжээ. Судалгааны дүн мэдээлэлийг боловсруулахад тодорхой мэдээлэл, хээрийн ажиглалтанд тохиолдоогүй.

Дундговь аймгийн саарал чоно(*Canis lupus*)-ын тархац, байршил

Адаацаг 2, Дэлгэрцогт1, Дэлгэрхангай 2 саарал чоно тохиолдож байсан бол энэ судалгаанд Адаацаг 2, Дэлгэрцогт 1 чонын мөр дахин тааралдаж байгаа нь ойт хээр, хээрийн бүсийн чоно элбэгшиж тархац нутаг нь тэлэгдэж байгааг харуулж байна. Тус аймгийн нутаг дэвсгэрт саарал чоно өсөх магадлал байна гэж тогтоолоо.

Шар үнэг (*Vulpes vulpes*)-ний тархац, байршил, тоо толгой

Дундговь аймгийн хэмжээнд 54600 км² нутагт 1000 га-д 0.37 бодгаль ноогдох нягтшилтайгаар 2054 толгой шар үнэг тархан байршиж байна. Сүүлийн 3 жил байгаль цагуур, идэш тэжээлийн тааламжтай нөхцөл үүссэн нь түүний тоо толгойн нөөц нэмэгдэхэд хүргэсэн байна.

Хярс үнэг (*Vulpes corsac*)-ний тархац, тоо толгой

Дундговь аймгийн 54600 км² нутагт хярс үнэг тархан байршиж байгааг хээрийн судалгаагаар тогтоолоо. Дээрх нутагт 1000 га-д 0.07 бодгаль ноогдох нягтшилтайгаар 3822 орчим толгой хярс үнэг байна.

Монгол тарвага ховордсоноос хярс үнэгний гол байрлан амьдрах нөхцөл муудсан боловч сүүлийн жилүүдийн байгаль цаг уур, идэш тэжээлийн тааламжтай нөхцөл бий болсон тул хярс үнэгний тоо толгой өсөх хандлагатай байна.


Халздай дорго(*Meles meles*)-ны тархац, байршил, тоо толгой

Дундговь аймгийн хэмжээнд 1980-1990 оны үед 2800 ширхэг доргоны арьс тушааж байсан байна. Энэ удаагын хээрийн судалгаа хийсэн дэлгэц нутагт доргны ямарч шинж тэмдэг тохиолдоогүй ба мэдээлэл өгсөн байгаль хамгаалагчид, иргэдээ авсан мэдээнд дорго байхгүй гэсэн байна. Дорго нэн ховордсон гэж тогтоосон. Мөн үүнтэй

нэг нь адил Хотны үен(*Mustela nivalis*, Өмхий хүрнэ (*Mustela eversmanni*)-гийн тархац, байршил, тоо толгой ховордсон нь олон жил дараалан ган, зуд, хуурайшлаас тэдгээрийн идэш тэжээл болох мэрэгчид, шавж, хоёр нутагтан зэрэг амьтад ховордсон, хоргодох нүх, эчээ, үүр байр элсэнд дарагдаж сүйрсэн зэргээс усдаж үгүй болох аюул тулгарсан байж болох үндэслэлтэйг тогтоосон.

Агнуурын бүс нутаг

Дундговь аймгийн Ерөнхий агнуур зохион байгуулалт, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 273 дугаар тогтоолоор дэмжүүлэн, БОНХЯамаар батлуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар Баянжаргалан, Өлзийт, Гурвансайхан, Сайхан-Овоо, Дэлгэрхайнгай, Өндөршил зэрэг сумдад Агнуурын бүс нутгийг тогтоож, менежментийн төлөвлөгөөгөө батлуулсан.



Агнуурын бүс нутгийн судалгаа 2015 он

№	Сумын нэр	Агнуурын бүсийн нэр	ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	Агнуурын бүсийн талбайн хэмжээ га	Менежмент хариуцагч ААНэгжийн нэр
1	2	3	4	5	8
1	Өлзийт	Уул алтаргана	2015.07.23 19	7.650	Нью жуулчин турс ХХК
2	Баянжаргалан	Аргын хад, Шивээгийн уул	2015.07.31 32	10.000	“Аанар” ХХК
3	Гурвансайхан	Гурвансайхан	2014	10.727	Би Ти энд Ти Си ХХК

2015-2016 оны төлөв байдлын тайлан

4	Сайхан-Овоо	Ахар уул	2015.04.02 35		Натурал ай эн эн ХХК
5	Дэлгэрхангай	Улаан хад	2015.08.10 23	4.384.0	Натурал ай эн эн ХХК

2016 онд агнасан ан тоо толгой, төлбөр хураамжийн орлого

№	Сум	Агнасан амьтан	2015		2016	
			Тоо	Төлбөр	Тоо	төлбөр
1	Гурвансайхан	Аргаль	2	35.824.710	1	19.650.000
2	Өлзийт	Аргаль	-	-	2	41.796.000
3	Баянжаргалан	Аргаль	-	-	1	20.000.000
4	Сайхан-Овоо	Тэх	-	-	1	4.036.000
	Нийт дүн			35.824.710		85.332.000

Биотехникийн арга хэмжээ


№	Сумын нэр	Агнуурын бүсийн нэр	Менежмент хариуцагч ААНэгжийн нэр	Зардал	
				2015	2016
1	2	3	4	5	6
1	Өлзийт	Уул алтаргана	Нью жуулчин турс ХХК	-	-
2	Баянжаргалан	Аргын хад, Шивээгийн уул	“Аанар” ХХК	-	-
3	Гурвансайхан	Гурвансайхан	Би Ти энд Ти Си ХХК	350.00 0	500.0 00
4	Сайхан-Овоо	Ахар уул	Натурал ай эн эн ХХК	-	1.900 .000
5	Дэлгэрхангай	Улаан хад	Натурал ай эн эн ХХК	-	1.120 .000
	Нийт			350.00 0	3.520 .000

Агаарын чанарын төлөв байдал

Агаар дахь бохирдуулагч бодисын агууламж нь цаг агаарын үзэгдэлтэй тодорхой хэмжээгээр хамааралтай бөгөөд жилийн дундаж агууламжаар авч үзэхэд агаар дахь бохирдуулагч бодисны хэмжээ **хүлцэх агууламжаас /цаашид ХА гэх/** давсан тохиолдол илрээгүй байна. /Агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээ нь цаг агаарын нөхцөл байдалтай харилцан уялдаатай байдаг температур, салхи, даралт/

2015 оны бүх хугацааны хэмжилтийн үр дүн хүлцэх агууламжаас давсан тохиолдол илрээгүй байна.

Мандалговь хот орчмын агаар дахь хүхэрлэг хий, болон азотын давхар ислийн дундаж агууламж



2015 оны жилийн дундаж агууламжаар Мандалговь хотод хүхэрлэг хийн индекс 12.8 азотын давхар ислийн индекс 10.4 Агаарын чанарын индекс маш сайн түвшинд байсан ба эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй байсан боловч сүүлийн жилүүдэд агаар дахь бохирдуулагч бодисын агууламж тасралтгүй өсөх хандлагатай болсон байна.

Агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээ өсөх болсонтой холбоотойгоор цаашид зөвхөн түгээмэл тархалттай хольцуудыг хянах хангалттай биш бөгөөд

нарийн ширхэглэгт тоосонцор, угаарын хий хаягдал утааны хяналт шинжилгээг хийх цаашилбал агаарын чанарын харуулын тоог нэмэх явуул судалгааны тохиромжтой багаж хэрэгсэлээр хангагдах шаардлага зүй ёсоор тулгараад байна.

Ногоон байгууламж

“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд цөлжилтийг бууруулах, элсний нүүдлийг багасгах иргэдийг идэвхижүүлэх зорилгоор 2014 оны 05 сарын 12-ны өдөр “Аривжих төгөл”-д 5 га талбайд мод тарих ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх нь цөлжилт, хөрсний доройтол, элсний нүүдэл тоосжилтыг сааруулах үндсэн зорилт болоод байна. Сум, байгууллага,

Ойжуулалтын ажлын хүрээнд Ойн зурвас байгуулах ажилд 20 га-д 12000 ширхэг суулгац, “Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 5 га-д 3000 ширхэг суулгац, мод үржүүлгийн газарт 15000 ширхэг мөчир тарьж усалгаа арчилгааг хийж байна. Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд 25 га-д 15000 ширхэг мод тарьсан.

Байгалийн нөөц баялгийн ашиглалт, хамгаалалт, ой зохион байгуулалтын талаар:

Ö°ëæèèðèéí °í°ãèéí áàéääë.

Óóð àìüñãàèüí òýò äóèààðàèò, õóð òóíàããñíü áóóðàèò, øíðííí øóóðãà àíèíí òç÷òýé ñàèðèéíü äààðããããè íýíýããñýí çýðýã áàéããèü òãã óóðúí òàããçé í°ðöèççä áýè÷ýýðèéí òàèðàèèãè, àãòí, çàí àøèàð àèèòàè èéáíðèíð, òàéãóóè çýðýã íü áýè÷ýýðèéí ãàçàð íòðãèéã, óðãàèèàí í°ð°ãèéã ýäóóðóóèæ, ö°ëæèèð°ä °ðð°ð í°ðöèèéã áçðäççèñýí áàéíà. Ñççèèéí æèèççäýã àéíàèéí íèèð íóòãã áýãñãýðò äáí áíèæ, ççíèè äààðàèæ, òóððò àððàé °äðèéí òíí æèè áçð íýíýããýæ, í°í òç÷òýé øíðííí øóóðãà, ñàèðèèàé õííãèéí òíí íýíýããýæ, íýðãýæèèéí áàéãóóèèããããñ òèèñýí äçáíýèðýýð áýè÷ýýðèéí óðãàèèèüí òýíæýý, ò°ð°è ñççèèéí 10 æèèä 30 òóãèèð áóóð÷ýý.

хамрагдах бөгөөд тэдгээрт 4 гүн өрмийн худгийг гаргуулж, цахилгаан дамжуулах агаарын шугаманд холбосон Хулдын Цагаанчулуу, Дэрэнгийн Хөтөл ус, Сайнцагааны Аривжих зэрэг хэд хэдэн газарт 10-32 га талбайг хашиж мод сөөг, бэлчээрийн ургамал тариалж байна.

“Бэлчээр сайжруулах экологийн туршилт, судалгааны төв”



5.1 Ойн талаар авч хэрэгжүүлсэн ажил

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигын дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны чиглэл болон аймгийн Засаг даргын Захирамж, албан даалгавар гаргуулан, сумдад дэд ажлын хэсэг байгуулан “Мод тарих үндэсний өдөр”-ийг зохион байгуулж, 1 модны экологи, эдийн засгийн үнэ цэнийг иргэдэд ойлгуулан, экологийн боловсролыг дээшлүүлэх, ой модоо нөхөн сэргээх, хот суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар хүний эрүүл орчинд амьдрах таатай нөхцөл бүрдүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх замаар хэрэгжүүлэн ажилладаг.

Энэ ажлын хүрээнд 2014 онд бүх нийтээр мод тарих ажлын хүрээнд 325 аж ахуйн нэгж байгууллагын 4039 иргэн 7 нэр төрлийн 16730 ширхэг мод, сөөг, 2015 онд 168 аж ахуйн нэгж байгууллагын 5413 иргэн 7 нэр төрлийн 35307 ширхэг мод, сөөг тариад усалгаа арчилгаа хийсэн байна.

**“Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр тарьсан
модны судалгаа /сум/ /2015 оны байдлаар/**



Тус аймагт бүх нийтээр мод тарих өдрийн нээлт, тарьц суулгацны үзэсгэлэн худалдааг Сум дундын ойн ангитай хамтран жил бүрийн 5 дугаар сард зохион байгуулан ажилладаг. 2015 онд аймгийн хэмжээнд 38207 ширхэг мод сөөг тарьснаас Гурвансайхан суманд “Цэцэрлэгжилт ХХК” 6800, “ЖИ Пи Эф” ХХК 1400, “Хөдөөгийн эмэгтэйчүүдийн холбоо” ТББ 7 суманд 9700 мод тарьж манлайлан ажилласан байна.


Он	Бут, сөөг тариалалтын тоо	Оролцсон иргэд, аж ахуй нэгж	
		Иргэн	ААН

2015-2016 оны төлөв байдлын тайлан

2014	16730	4039	325
2015	38207	5413	198


“Баян тооройн говь” ТББайгууллагын тэргүүн Тамир хүү Батчулууныхаа хамт хашаандаа үржүүлгийн зориулалтаар мөчрөөр 20000 гаруй сухай, улиас 1000, тоорой 300 ширхэгийг, гүйлс, монос, хайлаасыг хүлэмжинд үрээр, үхрийн нүд, чацаргана, шар хуайсыг суулгацаар нийт 30000 гаруй мянган мод тарьсан.

**Бүх нийтийн хөдөлгөөнд хамрагдсан ААН болон иргэдийн тоо
/ 2015 оны байдлаар /**



Аймгийн Засаг дарга, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын хооронд 2014, 2015 онд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын бодлогыг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээ, Аймгийн Засаг даргын захирамж, аймгийн Худалдан авах ажиллагааны албаны зөвлөмжийг үндэслэн сумдуудад Ойн зурвас байгуулан ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 18000 суулгац тарьж усалгаа арчилгааг хийсэн. Дээрх 2 жилийн тариалалтын ажлыг Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тухайн онуудад модны ургалтыг 75,0-86.94 хувьтайгаар хүлээж авсан.

**Ойн зурвас байгуулах ажлын хүрээнд тарьсан мод
/2014, 2015 оны байдлаар/**




Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, аймгийн Байгаль орчны газар, Сум дундын ойн ангиудын хооронд гурвалсан гэрээ байгуулан Сайнцагаан сумын “Аривжих төгөл”-д 5 га талбайд улиас, хайлаас, сухай, бургас, шар хуайсны 3000 тарьц суулгацыг тарьж, усалгаа, арчилгааг хийж ургалт 79.2 хувьтайгаар хүлээж авсан.

“Арвжих төгөл”-д тарьсан модыг хамгаалах, ургалтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор хашаажуулах ажлыг сум орон нутаг өөрийн хөрөнгөөр, модны усалгааг тогтмол байлгах үүднээс төгөлийн хашаан дотор 25-ийн 2 ширхэг ёмкосийг суурилуулж, улсын төсвийн хөрөнгөөр худаг гаргах асуудлуудыг тус тус зохион байгуулсан байна.

Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд цөлжилт, элсний нүүдэл, шар шороон шуургыг бууруулах зориулалтаар Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Сум дундын ойн ангиудын хооронд гурвалсан гэрээ байгуулан 10 га талбайд ойн зурвас байгуулж, 6000 мод, сөөг тарьж усалгаа арчилгааг хийлээ. Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг модны ургалтыг 75,0-81,2 хувьтай хүлээж авсан.

“Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд тарьсан модны тоо

/2014, 2015 оны байдлаар/



Бусад сумд төвдөө мод тарьж ногоон байгууламж бий болгож, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг зэрэг төсөвт байгууллагууд орчиндоо мод, сөөг тарихаас гадна тусгай талбайг сонгон авч мод тарьж ургуулах эхлэлийг тавьж байна.


Ногоон ажлын байр бий болгов

Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгуулсан ойн зурвасын усалгаа арчилгаанд аймгийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран ажилгүйдлийн бүртгэлд бүртгэлтэй иргэдтэй 5-9 сарын хугацаанд гэрээ байгуулан мод тарих, усалгааны ёмкост суурилуулах, хашаа барих, хамгаалалтын ойн зурвас байгуулах, өмнөх жилүүдэд тарьсан болон шинээр тарьсан модны усалгаа, арчилгаа, тордолтыг тогтмол хийлгэж түр ажлын байраар хангаж ойжуулалтын ажлыг зохион байгуулж ирсэн.

Эзэнтэй Монгол хөтөлбөрийн хүрээнд ногоон ажлын байр бий болгох зорилгоор хуучин талбайнуудад усалгаа хийхээр Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй давхардсан тоогоор 68 иргэнийг 5 сараар ажлуулсан.

Сайхан-Овоо сум ногоон байгууламж байгуулж, чацарганы төгөл байгуулах зорилт тавьсаны үндсэн дээр сумын төвийн ажилгүй иргэдийг бүл болгон 10 га газарт ойн зурвасын арга хэмжээний хүрээнд 6000 ширхэг чацаргана тариалсан. Хашаа хамгаалалт усалгааны асуудлыг орон нутаг хөгжүүлэх сангаар шийдвэрлэж өгсөн. Үүний үр дүнд 20 ногоон ажлын байр бий болгосон.

Ногоон ажлын байранд ажилласан иргэдийн тоо



Ойжуулалтын ажлын хүрээнд Ойн зурвас байгуулах ажилд 10 га-д 6000 ширхэг суулгац, “Ногоон хэрэм үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 10 га-д 6000 ширхэг суулгац, мод үржүүлгийн газарт 17000 ширхэг мөчир, хүлэмжинд хайлаас, бүйлс, шар хуайсыг үрээр, тарьж усалгаа арчилгааг хийж байна.

2015 оны байдлаар Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд 20 га-д 12000 ширхэг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэд өөрийн хөрөнгөөр 38207 ширхэг, мод сөөг тариад байна.

Олон улсын цөлжилттэй тэмцэх өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд “Газрын хөрс бол үнэгүй зүйл биш. Эрүүл хөрсөнд хөрөнгө оруулцгаая” гэсэн НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газраас гаргасан уриан дор орон нутгийн “Цоглог”, болон “Маргад” телевизээр мэдээлэл хийж “Бэлчээрийн сэлгээ хийх нь” баримтат киног гаргалаа.

Цөлжилт, элсний нүүдэл, шар шороон шуургыг бууруулах, бэлчээрийн доройтлыг багасгах зорилгоор Хятад улсын ӨМӨЗО-ны Хянган аймагтай хамтран ажиллах гэрээ байгуулж 60 га талбайд алтан харгана тарихаас энэ онд Дэлгэрцогт сумын төвд 7 га, Өлзийт сумын Цагаан суварга жуулчны баазыг түшиглэж 10 га нийт 17 га талбайд тариад усалгаа арчилгаа хийж байна.

“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд цөлжилтийг бууруулах, элсний нүүдлийг багасгах иргэдийг идэвхижүүлэх зорилгоор 2014 оны 05 сарын 12-ны өдөр “Аривжих төгөл”-д 5 га талбайд мод тарих ажлыг зохион байгуулсан

Мод үржүүлгийн аж ахуй.

Төв суурийн газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын үр дүнг дээшлүүлэх нэгэн чухал нөхцөл нь нутаг орны хөрсөнд дасан зохицсон сайн

чанарын тарьц, суулгацыг зохих стандартын дагуу бэлтгэж тарилтад гаргах явдал юм. Аймгийн тарьц суулгацын нөөцийг Сум дундын ойн ангийн мод үржүүлгийн газар нийлүүлдэг.

2014 онд мод үржүүлгийн 5 га талбайд шинээр 20х6 хэмжээтэй мананжуулагчтай хүлэмж 1 ширхэг, 1 га талбайн дуслын усалгааны систем суурилуулсан. Мөн хайлаасыг үрээр, улиас, сухай, бургасны 15000 ширхэг мөчрийг үржүүлгийн зориулалтаар тарьж Засаг даргын А/599 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг ургалтыг 86 хувьтай хүлээж авлаа.

Тус талбайгаас улиас, шар хуайс, сухайны суулгац 7000 ширхэгийг гарган иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, сум орон нутагт захиалгын дагуу нийлүүлсэн.

2015 онд Мод үржүүлгийн талбайд шинээр өөрийн хөрөнгөөр 4120000 төгрөгийн өртөг бүхий 18х6 хэмжээтэй мананжуулагчтай хүлэмж 2 ширхэг, 1 га талбайн дуслын усалгааны систем суурилуулсан. Хайлаас, шар хуайс, бүйлсийг үрээр 20000-25000 ширхэг, улиас 10000, сухай 4000, бургас 3000 нийт 17000 ширхэг мөчрийг үржүүлгийн зориулалтаар тарьц суулгац ургуулж байна.

Тус онд мод үржүүлгийн талбайгаас улиас, шар хуайс, хайлаас, сухайны суулгац 11511 ширхэгийг гарган иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, сум орон нутагт захиалгын дагуу нийлүүлж байна.

“Баян тооройн говь” ТББайгууллагын тэргүүн Тамир хүү Батчулууныхаа хамт хашаандаа үржүүлгийн зориулалтаар мөчрөөр 20000 гаруй сухай, улиас 1000, тоорой 300 ширхэгийг, гүйлс, монос, хайлаасыг хүлэмжинд үрээр, үхрийн нүд, чацаргана, шар хуайсыг суулгацаар нийт 30000 гаруй мянган мод тарьсан.

Аж ахуйн нэгжийн нэр	Мод үржүүлгийн газрын байршил	Талбай /га/	Усалгааны нөхцөл	Тарьц, суулгацын төрлийн тоо		Тарьц суулгацын нийт дүн /ш/	
				2014	2015	2014	2015
Сум дундын ойн анги	Харуултад	5.2	Гүнхий худаг хагас автомат	8	8	15000	17000
Баян тооройн	Сайнцагаан сум		Зөөврийн усалгаатай	-	9	-	21300


ГОВЬ							
ТББ							

Гадаргын болон гүний усны төлөв байдлын өөрчлөлт:

Оог аеиаа иу аиау оуудеэи аунуа идәиа, ооодае оод аиунааеодае, аеаа идіо оод ооіааиу оуіауу аааа, аақдуй аидо оніу іоо оуцааадеаааае, ааеааеэеі оуіоауо дадүоаіаоэ ааааодае, оніу дадооёаа, удауһаеөө оіаодуе рі.

БОАЖСайдын 2011 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн № А-124 улсын усны тоо бүртгэл явуулах тухай тушаал, Усны газрын даргын 2011 оны 05 дугаар сарын 25-ны №А-32 Усны тоо бүртгэлийг орон нутагт зохион байгуулах тухай тушаал, удирдамж, БОСайдын 2007 оны 269 тоот тушаалаар батлагдсан “Усны тоо бүртгэл явуулах журмын дагуу усны тооллогыг 2011 оны 05 дугаар сарын 27-оос 06 дугаар сарын 18-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

Тооллогоор аймгийн хэмжээнд нийт 2865 худаг, 139 булаг, 1 гол, 7 нуур, 2 рашаан, 3 цооног тоологдсон.



Ус иауһиее оодоаодеаа оудуаеиуу аеуо аеуи оидууіа “Иаиі-одоаеэ Аоіааіау” хөтөлбөр, аоіа ооааааіу оооаеоаа аіеіаидооёа аймгийн ИТХТ-н 2011 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн №17 дугаар тогтоолоор батлуулан ажиллаж ааеіа. Үүнд 6-н үндсэн зорилго дэвшүүлсний нэг нь усны асуудал юм.

2011-2012 онд улсын төсвийн 1306.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар бэлчээрийн болон аймаг, сумын төвийн ойролцоо мод тарих, газар тариалан, фермерийн аж ахуйд зориулан аймгийн хэмжээнд нийт 82 худаг гаргаж худгаа ажлын хэсэг, эзэмшигчдэд хүлээлгэж өгөөд байна. Үүнээс 20 орчим худаг мод чацаргана төмс, хүнсний ногоо малын тэжээлийн ургамал тарих, фермийн аж ахуйд зориулан гаргасан.




Улсын усны тооллогын ажил

Худгийн талаархи судалгаа

1	Ñóìúì íýð	Êîä	Áéìäèéí ò°á°°ñ àëñëääñàí çàé/èì/	Xóääã		
				Áçää	Èíæáíáðèéí	Ýíäèéí
1	Äýëäýðöíãð	08-01	44	224	15	209

2	Äýðýí	08-02	66	263	49	214
3	Áîâü-Óõòààè	08-03	101	203	87	116
4	Öääááíáýèäýð	08-04	148	152	32	120
5	Áàýíæàðääèàí	08-05	148	145	21	124
6	ªíä°ðøèè	08-06	182	125	16	109
7	Áóðääíñàéõàí	08-07	71	257	27	230
8	ªëçèèè	08-08	98	247	52	195
9	Öóèä	08-09	98	164	20	144
10	Ëóóñ	08-10	50	166	37	129
11	Äýèäýððàíääé	08-11	130	192	35	157
12	Ñàéõàí-Îâîñ	08-12	209	134	9	125
13	Ýðäýíýääèèé	08-13	114	376	6	370
14	Äääàöää	08-14	104	316	5	311
15	Ñàéíöääääí	08-15	-	179	58	121
Íèèè				3143	465	2674

Áóèää òñíú ýðèèä õàìääàèèð à÷ õíèáíääèüä ñóðòàè÷èèæ æèè á¿ð усны тухай танилцуулга боршур гаргах гэх мэт òíàíðõíé àæèüä õèéæ áàéíà. Àéíàèéí Çàñàä ääðäá болон БОАЖСайдын хооронд 2011 онд б¿тээгдэх¿¿н нийл¿¿лэх санх¿¿ж¿¿лэх тухай гэрээнд тусгагдсан булгийн эхийг хашиж хамгаалах ажлын гүйцэтгэлийг 9 áóèèèéí ýðèèä õàìääàèèæ òíðèæóóèèð ажлыг усны ìýðäýæèèéí байгууллага болох “Чандмань-Дундговь” ХК хий ж гүйцэтгэн ажлын хэсгийн актаар хүлээн аваад байна.



Газрын доорхи усны хяналтын сүлжээ байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн УСХХүрээлэн 2 цооног өрөмдөж нийт 8.947.784 төгрөгний үнэтэй багаж тоног төхөөрөмж хүлээн авсан.



Үгээр нь агаараа өсгөх үндэслэлээр нь хийж байна, үндэслэлээр нь хийж байна.

Улсын хөрөнгө оруулалтаар өнгөрсөн 5 жилийн хугацаанд ундрага нь дарагдаж ширгэх аюулд ороод байсан 30 булгийн эхийг хашиж хамгаалаад байна.




Шороон шуурга




Эрэг нурж дарагдсан булаг

ТХГНутгийн хэмжээ 2013 оны 12 сарын байдлаар 140 газрын 840471,1 га талбай буюу 11,25 % хувьд хүрээд байна. үүнээс гадна Сайхан-Овоо, Говь-Угтаал, Баянжаргалан зэрэг сумдууд сумынхаа нийт нутаг дэвсгэрийг тусгай хэрэгцээнд аваад байна. 2014 онд Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн талбай цуцлагдаж сумын ИТХ-ын 2014 оны 04-р сарын 09-ний өдрийн 03-р тогтоолоор 3475,54 га талбайг орон нутгийн хамгаалалтанд аваад байна. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтыг сайжруулах, тухай бүс нутаг оршин суудаг малчин өрхүүдэд сургалт, мэдээллийг Байгаль хамгаалагчдаас тогтмол хийлгэж байна. Мөн Байгаль хамгаалах арга хэмжээний зардлаас Аргийн хад, Дэл, Хөнжлийн уул, Суман хайрхан, Тогоогийн рашаан орчмын хамгаалалтын газруудад сурталчилгаа, мэдээллийн самбар хийж байршуулсан.



АШИГТ МАЛТМАЛ

2014.11.25-ны байдлаар нийт 168 тусгай зөвшөөрөл байгаагаас ашиглалтын 70 тусгай зөвшөөрөл 68758.58 га, хайгуулын 98 тусгай зөвшөөрөл 772617.76 га талбай олгогдсон байна. Ашигт малтмалын төрлөөр нь авч үзвэл гөлтгөнө 12, нүүрс 12, жонш 24, алт 3, мөнгө-алт 1, төмөр 6, төмөр-цайр 1, барилгын материал 9, өнгөт металл 1, литий 1 гэсэн байдлаар олгогдсон байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНэгжийн хөрөнгө оруулалтын 41 нь дотоодын, 29 нь гадаадын хөрөнгө оруулалттай байна. 2015.12 сарын байдлаар нийт 178 тусгай зөвшөөрөл 847.3 мян.га буюу нийт нутаг дэвсгэрийн 11.3 хувь, үүнээс ашиглалтын 79 буюу 128.8 мян.га нийт нутаг дэвсгэрийн 1,7 хувь, хайгуулын 99 буюу 718.5 мян.га нийт нутаг дэвсгэрийн 9.6 хувь эзэлж байна. Мэдээллийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмалын газрын <http://www.mram.gov.mn/> вэб сайтаас





Уул уурхайн нэгдсэн хяналт, шалгалт

2014 онд Аймгийн МХГазрын дагын 13-05-003/59 тоот удирдамжийн дагуу Дундговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжид хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Тус хяналт шалгалтанд аймгийн МХГазар, Онцгой байдлын хэлдтэс, Тагнуулын хэлтэс, ГХБХБГазар, Хөдөлмөрийн хэлтэс, ИХШХЕГазрын Дундговь аймаг дахь төлөөлөлгч гэсэн бүрэлдэхүүнтэй ажилласан.

Хяналт, шалгалтын явцад Гувь-Угтаал сумын “Чин хаш” ХХК, Гурвансайхан сумын “Жи Пи Эф” ХХК, “Билэгт хайрхан уул” ХХК Баянжаргалан сумын “Эм Си Ти Ти” ХХК, “Шианганюнтун” ХХК, “Үнэн анд” ХХК, “Монголросцветмет” ХХК, Өлзийт сумын “Адил-Оч” ХХК зэрэг нийтдээ 8 ашиглалтын болон хайгуулын аж ахуйн нэгж хамрагдсан.

Гурвансайхан сумын Чулуут багийн Зүүн гэх газарт ашиглалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй “Жи Би Эф” ХХК-д аймгийн МХГазрын даргын удирдамжын дагуу хяналт шалгалтын ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийлээ.

Тус ААН нь MV-017368 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, 9011261016 бүхий улсын бүртгэлийн гэрчилгээтэй, нийт 303,92 га талбайд үйл ажиллагаа явуулах эрхтэй салхитын мөнгө болон алтны үндсэн ордыг ил уурхайн аргаар 8 жилийн хугацаанд олборлолт хийнэ. 60% дотоод, 40% гадаад хөрөнгө оруулалттай.

2015 онд Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа ААНэгжид Аймгийн МХГазар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын

хэлтэстэй хамтран 2015 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн нэгдсэн шалгалтыг зохион байгуулсан. Тус нэгдсэн шалгалтаар Гурвансайхан, Баянжаргалан, Өлзийт, Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй 7 ААНэгж хамрагдсан.

**Байгалийн өнгөт чулууг хууль бусаар түүх,
ашиглахтай тэмцэх чиглэлээр**

Одоогийн байдлаар Адаацаг, Дэлгэрцогт, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Баянжаргалан, Өндөршил зэрэг сумын нутгаас газрын байгалийн өнгөт чулууг хууль бусаар түүдэг зөрчил 2008 оноос хойш гардаг болсон. Дээрх сумдаас Дэлгэрцогт сумын нутгаас хууль бусаар чулуу түдэг, ухдаг асуудал газар авч хөрсний өнгөн хэсэг буюу үржил шим /50 см хүртэл хөрсөн бүрхэвч/-т хэсэгт хохирол учруулж, ухаж эвдээд байна.

Дэлгэрцогт сумаас түүж байгаа чулуунаас дээж авч Геологийн төв лабораторит дээж өгч шинжилгүүлэхэд байгалийн өнгөт Манын төрлийн Цахиур чулуу гэж тогтоогдсон.

Аймгийн Цагдаагийн газраас иргэдийн түүсэн, худалдан авсан чулууг хилийн боомтуудаар хууль бусаар гаргадаг талаарх мэдээллийн дагуу Өмнөговь, Дорноговь аймгийн Тагнуулын газар, Хил хорио цээрийн хяналтын хэлтэст албан бичиг хүргүүлэн хамтран ажиллаж байна.

Дэлгэрцогт сумын төвд хууль бусаар чулуу түүж байгаатай холбогдуулан иргэдэд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн хүүхдүүдийн дунд нийт 4 цагийн сургалт зохион байгуулсан.

2015 онд Дэлгэрцогт сумын нутгаас хууль бусаар чулуу түүх асуудлыг таслан зогсоох зорилгоор цагдаагийн газар, Тагнуулын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран гэнэтийн үзлэг хийж, ихээхэн хэмжээний чулуу багаж хураан аваад байна.

Шалгалтаар илэрсэн зөрчил

№	Шалгалтын тоо	Зөрчил гаргасан иргэд	Журамлагдсан тээврийн хэрэгсэл	Худалдан авагч иргэд	Торгуулийн бүрдүүлэлт /сая/ төг
1	7	120	34	16	14.0

Дээрх хууль бус үйл ажиллагааны улмаас нийтдээ 12 газарт 98.000 м² буюу 9.8 га талбай ухагдаж, хөрсний үржил шимт өнгөн хэсэгт доройтол бий болсон.

2.1.3. Бичил уурхайн үйл ажиллагаа

2014 оны байдлаар Бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа нөхөрлөлүүд болон худалдан авалт хийж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд МХЕГазар, АМГазар, аймгийн МХГазар, Тагнуулын хэлтэс, аймгийн Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагуудын бүрэлдэхүүнтэй Хяналт шалгалтыг Хулд сумын Түймэрт цагаан гэх газарт бичил уурхайн хэлбэрээр нөхөрлөлийн зохион байгуулалтанд орж ашигт малтмал олборлож байгаа 14-н нөхөрлөл, жонш худалдан авч байгаа “Өлгийн говь” ХХК, “Эм Жи Би” ХХК-ууд, Өлзийт сумын Шарангад гэх газар бичил уурхайн хэлбэрээр нөхөрлөлийн зохион байгуулалтанд орсон 8 нөхөрлөл, жонш худалдан авч байгаа компаниуд хамрагдсан.

Шалгалтаар ажлын хэсэг Хулд сумын “Түймэрт цагаан”-ны бичил уурхайн Уулын ажлын төлөвлөгөөгүй олборлолт явуулж буй талбайнуудын мөргөцөгийн өндөр, налуугийн өнцөг зэрэг нь ил уурхайн стандарт хэмжээг зөрчсөн гүн нь 50-60м хүрсэн.

Ажлын хэсэг ярилцан тухайн газар дээр явагдаж байгаа үйл ажиллагаа нь байгаль орчин болоод бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн ажиллаж байгаа зүйл огт байхгүй цаашид хүний амь нас болоод эрүүгийн хэрэг гарах нөхцөл байдал үүссэн байна гэсэн дүгнэлт гаргаж улсын байцаагчдын хамтарсан акт тогтоон нөхөрлөлийн болон худалдан авалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шийдвэрт хүрч үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоосон.

Аймгийн хэмжээнд 2015 оны байдлаар Өлзийт сумын 4 дүгээр багийн нутаг Шарангад, Луус сумын суврага багийн нутаг Шаргал, Хулд сумын шувуутай багийн нутаг Түймэрт цагаан зэрэг газруудад бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж байна. Дээрх бичил уурхайн нөхөрлөл, ААНэгжийн гишүүдэд холбогдох байгууллагатай хамтран хяналт шалгалт зохион байгуулж, сургалт мэдээлэл хийгээд байна. Мөн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон холбогдох байгууллагуудын удирдлагуудын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажиллаж 2015 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 53 дугаар тогтоолоор дээрх бичил уурхайн үйл ажиллагааг зогсоож, гарсан зөрчлийн арилгах шаардлага өгч ажилласан. Уг шаардлагын дагуу зарим уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцлийг сайжруулж, техникийн нөхөн сэргээлтийг чанартай хийсэн гэх улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн Өлзийт сумын 4 дүгээр багийн нутаг Шарангад,

Луус сумын суврага багийн нутаг Шаргалын бичил уурхайн үйл ажиллагааг нээгээд байна. Хулд сумын Түймэрт цагааны бичил уурхайг дээрх шаардлагыг хангасан тохиолдолд нээх тухай шийдвэрийг гарсан бөгөөд холбогдох байгууллагын удирдлагуудад байнгын хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон.

2015 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2015 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө болон хайгуулын ажлын төлөвлөгөөг зохих байгууллагаар батлуулсан ААНэгжийн гүйцэтгэлд аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан байнгын ажлын хэсэг ажиллуулж, акт үйлдэн хүлээн аваад байна.

Уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг Үнэн-Анд ХХК, Монросцветмет ХХК, Эм Си Ти Ти ХХК, Тайшен девелопмент ХХК, Чинхаш ХХК, Мирайфлюорид ХХК, Жи Фи Эф ХХК, Түмэн тал ХХК, Тэвшийн говь ХХК зэрэг ААНэгжүүд БОМТөлөвлөгөө батлуулсан. Мөн хайгуулын төлөвлөгөө батлуулсан 14 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 11 ААНэгж БОМТөлөвлөгөөгөө хянуулсан байна. Нийтдээ 24280.0 мян. төгрөг төлөвлөн батлуулсан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

Байгаль орчны багц хууль батлагдан дагаж мөрдөх журамд өөрчлөлт орсны дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний журам өөрчлөгдөж, шинэчилсэн аргачлалаар үнэлгээ хийгдэж байна.

2014 онд нийт 14 төсөлд хүсэлтийнх нь дагуу дүгнэлт гаргасан байна.

Шатахуун агуулах, борлуулах төсөл 7, Дэд бүтцийн төсөл 3, Амралт, сувилалын төсөл 1, Шингэрүүлсэн хийн төсөл 1 үнэлгээ хийгдсэн.

2015 онд Аймгийн УЦУОШАлбаны Байгаль орчны шинжилгээний лаборатори, Буянт-Өргөө ХХК-ний Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр, Тэс петролиум ХХК-ний Шатахуун түгээх станц, Мандалговь хотод үйл ажиллагаа явуулдаг Ган-Илч ХХК-ний 6 зуух, Дундговь-Ус ХХК-ний 2 зуух, Тэвшийн говь ХХК-ний 2 зуух, Фамили партнерс ХХК-ний Өвлийн нарлаг хүлэмж, Адаацаг сумын Тавины булаг ШТСтанц, Наран булаг ХХК-ний ахуйн шавж, мэргэч устгах, ариутгах төслүүдэд хүсэлтийнх нь дагуу ерөнхий үнэлгээ хийв.

Байгалийн болон гамшигт үзэгдэлийн төлөв байдал

2014, 2015 онуудад Дундговь аймгийн хэмжээнд хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, цочир хүйтрэл болох цаг агаарын аюултай үзэгдэлээр анхааруулга мэдээ-2, урьдчилсан сэрэмжлүүлэх мэдээ 14 удаа, Урьдчилан сэргийлэх мэдээ-1

тус тус зарлагдснаас таарц 85.4 буюу 2.2%-иар өссөн, онч 94.4% буюу 5.6%-иар буурсан, аюултай болон гамшигт үзэгдлийг илрүүлсэн байдал 100% байлаа. Цаг уурын улсын сүлжээний өртөө харуулын 714 удаагийн аюул мэдээ зохиож өгсөн. Энэ жилийн хувьд цаг агаарын аюултай үзэгдлээс шалтгаалсан хохирлын мэдээ ирээгүй байна.

Байгаль орчны эрх зүйн

2012 онд байгаль орчныг хамгаалах тухай багц хуулиудад өөрчлөлт орж, үүнтэй холбогдуулаан УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, яамны сайдын тушаал, зэрэг эрх зүйн олон баримтууд шинээр гарч, байгаль орчны талаархи эрх зүйн орчин бүхэлдээ шинэчлэгдсэн нөхцөлд тайланд жилүүдийн үйл ажиллагаа явагдлаа.

Өнөөдрийн байдлаар Биологийн олон янз байдлын тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенц зэрэг 18 конвенц, олон улсын гэрээ, байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай, Усны тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Амьтны тухай, Ус бохирдуулагчийн төлбөрийн тухай, Ашигт малтмалын тухай зэрэг Монгол улсын 18 хууль, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр, Ус үндэсний хөтөлбөр, Хог хаягдлын, Удаан задардаг органик бохирдуулагч, Ойн тухай үндэсний хөтөлбөр, “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрүүд, УИХ-ын 43 дугаар тогтоол зэрэг дээрх шийдвэрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан байгаль орчны асуудал эрхэлсэн төв байгууллагын сайдын тушаал, аймаг сумдын ИТХ, Засаг даргын шийдвэрүүд нь байгаль орчны талаарх эрх зүйн орчныг бүрдүүлж байна.

2015 оны байгаль орчны шалгалтын дүнд нийт 371 зөрчил илрүүлж /давхардсан тоогоор/, үүнээс 340 буюу илрүүлсэн зөрчлийн 91.6%-ийг нь арилгуулан илэрсэн зөрчилд 18 шийтгэвэрээр 10054000 төгрөгний торгууль шийтгэвэр тавьж, үүнээс хуулийн байгууллагад 8256000 төгрөгний 9 захиргааны хэргийн материалыг шилжүүлсэн, 9 шийтгэвэрийн 1798000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж барагдуулсан. Мөн Амьтны тухай хууль тогтоомжийг зөрчсөн 1 иргэнээс 94414 дугаартай гол төмөртэй, 14621 замагийн дугаартай 250м тусгалтай калемар маркын бууг хураан авч Цагдаагийн байгууллагат шилжүүлсэн. Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн 28 иргэнээс 274 кг чулуу хураасан.

Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалт 97.6%, байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилт 85%-тай байна.


Байгаль орчны эсрэг гэмт хэргийн илрүүлэлт

Тайлант он	Ойн	Ан	Газар	БОНБУ	Ашигт малтмал	Хог хаягдал
2014	2	3	20	59	167	8
2015	-	4	-	37	319	11


Хог хаягдлын талаар :

2014 онд аймгийн хэмжээнд 373.3 аа 0àèáàéd хог хаягдал тархсан. Нийт 8196.3 тонн хог хаягдлыг жилд дунджаар хогийн цэгт зөөвөрлөдөг мөн нэгдсэн хогийн цэгт нийт 93 га талбайг шууж хогийн цэгийн талбай хэмжээг багасгах ажлыг зохион байгуулан ажиллаа.


Үүссэн хог хаягдлын хэмжээ-2014



2014 оны хог хаягдлын талбай



2015 онд аймгийн хэмжээнд 329.8 га талбайд хог хаягдал тархсан. Үүнд: Баянжаргалан 3.5 га талбай, Дэлгэрцогт-18 га, Цагаандэлгэр-6 га, Өлзийт-5 га, Дэрэн-0.8 га, Говь-Угтаал- 80 га, Гурвансайхан-13.6, Дэлгэрхангай 3.5, Сайхан-овоо- 3.2, Өндөршил-50 га, Хулд-4.5 га, Луус-0.5 га, Адаацаг-5.9 га, Эрдэнэдалай-12 га, Сайнцагаан-130га талбайг хамраад байна.




Бүх нийтийн цэвэрлэгээ

2014 онд Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 1/276 дугаар “Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу иргэдийг цэвэр эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, газрын хөрсний болон агаарын бохирдолыг бууруулах, хотын төвийн орчмын эзэнгүй хог хаягдлыг багасгах зорилгоор бүх нийтийн цэвэрлэгээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг

4499 иргэд, 202 аж ахуйн нэгж, байгууллагийн 150 тн хог, аймгийн төвөөс гадагш чиглэгдсэн хөдөөгийн багуудын зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээгээр ойролцоогоор 450 тн хог хаягдлыг цэвэрлүүлэн ачуулж хогийн цэгт буулгалаа.

Аймгийн хэмжээнд нийтийн цэвэрлэгээнд оролцсон иргэд, аж ахуйн нэгж байгууллагын тоон үзүүлэлт




Хог хаягдлын тооллого: Хог хаягдлын тухай хуулийн 6.1.4 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 288 тогтоолыг үндэслэн хог хаягдлын норматив тогтоох болон бүтэц тодорхойлох ажлыг зохион байгууллаа. Хог хаягдлын норматив болон бүтэц тогтоох ажлыг Цагаандэлгэр, Сайхан-овоо, Эрдэнэдалай, Сайнцагаан сумдуудаас нийт 369 айл өрхийг өвөл болон зуны тооллогын судалгаанд хамруулж өдөрт гарах хог хаягдлын бүтэц болон хэмжээг тогтоох ажлыг аргачлалын дагуу зохион байгууллаа. Аж ахуйн нэгж, байгууллагын судалгаанд нийт 195 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдалаа.

- + Нийтийн дотуур байр,
- + Зочид буудал, амралтын газар,
- + Их дээд ерөнхий боловсролын сургууль,
- + Номын сан музей,
- + Цэнгэлдэх хүрээлэн спортын ордон,
- + Сүм хийд олон нийтийн амралт зугаалгын бүсийн талбай,
- + Худалдааны төв зах дэлгүүр,
- + Ресторан бар кафе,


- ✚ Үсчин ахуйн үйлчилгээний цогцолбор гутал газар хувцас засвар оёдлын цех,
- ✚ Албан байгууллага оффис,
- ✚ Төмөр замын буудал автотээврийн товчоо,
- ✚ Нисэх онгоцны буудал,
- ✚ Эрүүл мэндийн байгууллага, нийтийн эзэмшлийн гудамж талбай цэцэрлэгт хүрээлэн олон нийтийн амралт зугаалгын бүс,
- ✚ Үйлдвэрлэл үйлчилгээний гэсэн төрлөөр хог хаягдлыг норматив тогтоох ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд норматив болон бүтэц тогтоох ажлыг зохион байгуулахад айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах хог хаягдал нь үйл ажиллагааны чиглэл болон иргэдийн амьжиргааны түвшин, улиралын онцлогоос болж өөр үүсч байна. Тус аймгийн хувьд говь цөлөрхөг хээрийн бүс зонхилдог учир ой мод байхгүй улмаас иргэд өвлийн улиралд аргаль, хөрзөн, мод, нүүрсийг голдуу галлагаандаа хэрэглэж байгаа бөгөөд нүүрс, аргаль хөрзөнгөөс хоногт 0.5-5 кг үнс гарч байна. Манай аймгийн хувьд зуны улиралд малчин өрхүүдэд цагаан идээ боловсруулан аргалийг их хэмжээгээр түлдэг бөгөөд малчин өрхийн хувьд өвлийн улирлаас бага хэмжээгээр үнс үүсч байна. Төвийн айл өрх болон аж ахуйн нэгж байгууллагаас хуванцар, гялгар уут, цаас нилээд их хэмжээгээр үүсч байна.


Зун болон өвлийн хог хаягдлын бүтэц /кг/-аар



Зун болон өвлийн хог хаягдлын норматив /кг/-аар



Өвөл зуны судалгаанд хамрагдсан сумдын айл өрхийн тоо



Аюултай хог хаягдал талаар:

“Дундговь-ус” ОНӨҮГазрын агуулахад он удаан жил хадгалагдаж байсан шингэрүүлсэн хлортой 10 ширхэг баллоныг “Тамбов-цэргийн химичид” ТББ-ын харъяа “ТВХ” ХХК-ний хадгалах байгууламжид шилжүүлэх ажиллагааг Салбар зөвлөлийн гишүүд болон бусад холбогдох албан тушаалтнуудтай хамтран явууллаа. Шингэрүүлсэн хлортой баллон хадгалж байсан барилгад хийсэн урьдчилсан үзлэгээр хлорын алдагдал илрээгүй, орчны цацрагын фон хэвийн хэмжээнд байсан. Баллон тус бүрийг тусгай зориулалтын лацаар лацдаж, Тээвэрлэх машинд шилжүүлэн ачсан. Уг ажиллагаанд оролцсон ОБХэлтсийн албан хаагчид зориулалтын хамгаалах хэрэгслийн болон галын машиныг бүрэн

цэнэгтэйгээр бэлэн байдалд байлгаж холбогдох хууль тогтоомж, журам зааврыг чанд сахин ажилласан бөгөөд гэрээ байгуулж, акт үйлдэн бичиг баримт бүрдүүлж аюулгүй ажиллагааг өндөр түвшинд зохион байгуулж хамгаалалттайгаар хадгалах байгууламжид хүргүүлсэн.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн дагуу Жи пи Эф ХХК-ны 5н төрлийн тэсэлгээний бодис монел, тэслүүр, импусс-185074 кг, эшн-15000метр, реле-135ш бодис, Наранбулаг ХХК-ны хортон шавж устгах ариутгах бодис жавель, хлорын шохой, домовой, жули, бромедлин 6 төрлийн 27150гр бүртэгжүүлж мэдээллийн санд баяжилт хийлээ. Эрдмийн далай цогцолбор сургуулийн химийн лаборторт ашиглагдаж байсан хугацаа дууссан Калиперманганат-670гр–ийг БОНХАЯамны харьяа химийн бодисын агуулахад хүлээлгэн өглөө.

Аялал жуулчлалын талаар:

БОНХАЖЯ, Монголын Аялал Жуулчлалын Холбоо хамтран зохион байгуулдаг уламжлалт “International Travel Mart”-2015 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 3-р сарын 21, 22-ны өдрүүдэд Мишээл Экспо Төвийн үзэсгэлэнгийн танхимд боллоо.

Тус үзэсгэлэнгээр Дундговь аймгийн “Онги-Оюуны энергийн төв”, “Цагаан суварга”, “Говь суварга”, “Бага газрын чулуу”, “Баянбулаг”, “Эрдэнэ-Ухаа”, “Төв боржигон”, “Сайхан говь”, “Дундговь”, “Онгийн нууц” жуулчны баазууд нэгдэж Дундговь аймгаа төлөөлөн дунджаар нэг бааз 50 орчим тур операторуудтай жуулчин хүлээн авах гэрээ байгуулж, аймаг орон нутгаа сурталчлан оролцов.

Тэмээн сүргийн өсгөх, үр ашгийг нэмэгдүүлэх, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Их говийн тэмээ-2015” арга хэмжээ 02 сарын 09-ны өдөр Дэлгэрхангай суманд зохион байгуулагдлаа. Тэмээн поло, Сайхан хос шалгаруулах, тором, бүдүүн тэмээний уралдаан, шилмэл буур, ингэ шалгаруулах, ингэний сүүний болон тэмээний ноосоор хийсэн бүтээгдэхүүний үзэсгэлэн зэрэг арга хэмжээ боллоо. Дундговь аймгийн Гурвансайхан, Сайхан-Овоо, Хулд зэрэг 6 сум, Өмнөговь аймгийн Ханхонгор, Мандал-Овоо зэрэг 3 сумын тэмээчид оролцлоо. Уг арга хэмжээний үеэр нутаг орон, тэмээчдийн ахуй соёлыг сурталчлах үүднээс “Тэмээчний нэг өдөр” нэвтрүүлэг хийгдэж MNB телевизээр орон даяар цацагдсан.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын “Баянбулаг” жуулчны бааз “Монголчуудын бичиг үсгийн гайхамшиг” төслийг хэрэгжүүлж хүннүгийн үеэс

монгол түмний хэрэглэж ирсэн тод үсэг, руни бичиг, эвхмэл үсэг, вагиндра үсэг гэх мэт 11 бичиг үсгүүдээр “Аяны өлзий орштугай” гэсэн үгийг байгалийн тогтоцоороо байгаа хадан дээр сийлбэрлэж жуулчдын татах үзмэрээ нэмэгдүүллээ. Мөн аргалийн хөшөөг босгосон байна.

Тухайн орныг сурталчлах зорилгоор зохион байгуулагддаг *Хонг Конгийн “Action Asia Events”-ээс* 2015 оны 06 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд *Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутагт орших “Бага газрын чулуу” байгалийн үзэсгэлэнт газарт Олон улсын марафоны тэмцээн “MONGOLIA ACTION ASIA 3 DAY ULTRA MARATHON” нэртэйгээр* зохион байгуулагдлаа. Уг тэмцээнд гадаадын 147 орчим гадаадын тамирчид ирж оролцлоо. *Оролцогчид 3 өдрийн туршид бартаат замаар өдөрт 60 км/100 км гүйсэн юм.* Оролцогчдын 80% нь Хонг Конг, Сингапур, Тайван, Токио, 20% нь Европ, Америк, Австралиас байсан бөгөөд Монголоос Нью жуулчин тур ХХК хамтран зохион байгуулагчаар орж, Бага газрын чулуун дах “Баянбулаг”, “Эрдэнэ-Ухаа” жуулчны бааз тамирчдыг хүлээж авсан.

Мэдээллийн лавлах 19001199 болон 19001950-д аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд, жуулчны бааз, зочид буудал, ресторан, аялал жуулчлалын эвент арга хэмжээ, урлаг соёлын байгууллагуудын талаарх аялал жуулчлалтай холбоотой бүхий л мэдээллийг мэдээллийн баазад нь оруулаад байна.

“E tech” компани БОНХАЖЯамтай хамтран аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор аялал жуулчлалын чухал цэгүүдийн гадна болон дотоод зураглалыг 360 градусуар дүрсжүүлэн авах “Google street view” төслийг хэрэгжүүлэхээр болсон.

Жуулчны баазуудын ногоон байгууламжийг бий болгох, дэмжих үүднээс Өлзийт сумын “Говь суварга” жуулчны баазад “Ойн зурвас байгуулах ажил-“ын хүрээнд 1 га талбайд 600 хайлаас тарьсан бөгөөд ургалтын явцад газар дээр нь очиж мод арчлах заавар зөвлөгөө өгч ажилласан.

БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Хянган аймагтай хамтран ажиллах гэрээний дагуу, цөлжилт элснй нүүдлийг сааруулах зорилгоор Өлзийт сумын Цагаан суварга жуулчны бааз дээр 10 га талбайд алтан харгана тарьсан.

Сүүлийн жилүүдэд аймгийнхаа байгалийн үзэсгэлэнт, түүх соёлын дурсгалт газрыг үзэх, хүүхэд залуучуудад сурталчлан танилцуулан, хайрлан хамгаалах зорилгоор улсын тусгай хамгаалалттай газар болон орон нутгийн тусгай

хамгаалалттай газруудаар ЕБС-ын сурагчид, төрийн албан хаагчдын нэг өдрийн эко аялал хийж хэвшсэн.

Дундговь аймагт хэрэгжиж буй GEOSOS системд аймгийн байгалийн үзэсгэлэнт газар, түүх соёлын дурсгалт газрууд, жуулчны бааз, рашаан сувилалын координатыг орууллаа. Ингэснээр аймагт ирсэн жуулчид уг апплекэйшн суулгаснаар аюулгүй аялах төөрсөн тохиолдолд тусламж дуудах боломжтой болно.

Дундговь аймгаар аяласан 2015 оны жуулчдын тооны судалгаа


№	Жуулчны бааз	Дотоод жуулчин	Гадаад жуулчин										
			БНХАУ	ОХУ	АНУ	БНСУ	Итал ь	Герман	Франц	Япон	Австра ли	Бусад	
1	Онгийн нууц	329	53		472	102		274				23	
2	Сайханговь		200										
3	Дундговь	2015 онд жуулчин хүлээж аваагүй.											
4	Бага газрын чулуу		Европ-200						Ази-150				
5	Сүм хөх бүрд	2015 онд жуулчин хүлээж аваагүй.											
6	Цагаан суварга	548		26	12	88	171	659	139			130	
7	Баянбулаг	272	10			30	80	0	100			207	
8	Эрдэнэ-Ухаа	200					141	159				200	
9	Онгийн хийд	150	50										
10	Өөшийн сувилал	430			20							32	
11	Говь суварга	250					250	100	250			150	

2015-2016 оны төлөв байдлын тайлан

12	<i>Онги-Оюуны энергийн төв</i>	400			80	75		64	54	38		89
13	<i>Төв боржигон</i>	200	450									
14	<i>Рашаантын ам</i>	<i>2015 онд шинээр нээгдсэн ирэх оноос эхлэн жуулчин хүлээн авна.</i>										
Ний т		2779	63	26	584	295	642	1306	543	38		831
	7907	2779	5328									



СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН ЖУУЛЧДЫН ТОО



Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 14 жуулчны бааз, рашаан сувилал байна.

2015 онд аймгийн хэмжээнд энэ гадаад, дотоодын нийт 7900 гаруй жуулчин хүлээж авсан нь 2014 оноос 19%-иар өссөн байна. Аялал жуулчлалаас олсон нийт орлого ойролцоогоор 783,500,000 орчим төгрөг байна.

2015 онд Сүм хөх бүрд, Дундговь жуулчны баазууд жуулчин хүлээж аваагүй. Аймгийн хэмжээнд ирсэн гадаад жуулчдын ихэнх нь Франц, Герман, АНУ, БНСУ, Япон, Итали орнуудын жуулчид байна. Сүүлийн жилүүдэд жуулчны тоо өмнөх онуудынхаас өссөн үзүүлэлттэй байгаа.

Тусгай хамгаалалттай 2 газар нэвтрэхэд хураамж авдаг.

1. “Бага газрын чулуу” тусгай хамгаалалттай газраар 670 гадаадын иргэн тасалбар авсан байна. Нийт орлого 2,000.000 төгрөгийг Дэлгэрцогт сумын төсөвт оруулсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн талаар:

Онгийн хийдийн аймгийн тусгай хамгаалалттай газарт. Онгийн хийдийн орчимд байрлах жуулчны баазууд нийтдээ 120 орчим мод, цэцгийн мандал тарьсан. Мөн долоо хоног тутамд 2 удаа ойр орчмын хог цэвэрлэх ажлыг зохион байгуулдаг. Нутгийн иргэд болон жуулчны баазуудын ажилчдад эрчим хүчээ хэмнэх, ирсэн жуулчдад байгаль орчноо хайрлан хамгаалахыг уриалах, иргэд болон жуулчны баазын ажилчдад эко угаалгын бодис хэрэглэх, ашиглах талаар төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулсан.

Сүм хөх бүрдийн аймгийн тусгай хамгаалалттай газарт. Сүм хөх бүрдийн ерөнхий төлөвлөгөө, сүм хөх бүрдийн байгаль орчныг нөхөн сэргээх, сүм хөх бүрд цогцолборын дэд бүтэц, цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөний барилга байгууламжын ажилд ОНХС-ийн хөрөнгө 260,0 сая төгрөгийн зураг, төсвийг хийлгэн хүлээн авч, худалдан авах ажиллагааны газраас нээлттэй тендер зарлаж, тендерт “Санжат” ХХК 2,1 тэрбум төгрөгөөр гүйцэтгэх санал ирүүлэн шалгарч гэрээ байгуулан ажлаа эхлүүлээд байна. Тус ажил он дамжин хийгдэх болно.

Дэл уулын аймгийн тусгай хамгаалалттай газарт. Дэл уулын орчмын эвдэгдэж эзэнгүй орхигдсон Шар хошуу, Хөтөл гэх 2 газрын нийт 10 га талбайг Швецарийн хөгжлийн агентлагийн “Азийн хөгжлийн сан”-ийн 39 сая төгрөгний хөрөнгө оруулалттайгаар техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг “Өлзийт хишиг” ТББайгууллага хийж гүйцэтгэлээ.

Загийн усны улсын тусгай хамгаалалттай газарт. Өлзийт сумын нутаг дахь Загийн усны заган ойд ой зохион байгуулалтын ажлыг Ойн судалгаа хөгжлийн төвийн захиалгаар “Денс форест” ХХК гүйцэтгэж байна. Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон комисс Загийн усны хоолой улсын тусгай хамгаалалттай газарт хулгайгаар заг бэлтгэх, ан амьтаны хууль бусаар агнахаас урьдчилан сэргийлж эргүүл шалгалтын ажил тодорхой хугацаанд зохион байгуулан ажиллалаа.

Цагаан суварга аймгийн тусгай хамгаалалттай газарт. БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах орны Хянган аймагтай хамтран ажиллах гэрээний дагуу, цөлжилт элсний нүүдлийг сааруулах зорилгоор Өлзийт сумын Цагаан суварга жуулчны бааз дээр 10 га талбайд алтан харгана үрээр тарьсан.

Дэлгэрхангай уул улсын тусгай хамгаалалттай газарт. Ховор ан амьтаны тооллого тандалт судалгааг орон нутгийн зүгээс 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран 1 нийт 2 удаа хийсэн. Үүний үр дүнд: Аргаль хонь 120 гаруй, Янгир 140 гаруй тоо толгой тогтвор сууршилтай нутагшиж байна.

Тусгай хамгаалалттай газруудад хийсэн хяналт, шалгалтын талаар.

Аймгийн МХГазар, Цагдаагийн газар холбогдох сумдын албан тушаалтантай хамтран хууль бус ангийн хяналт шалгалтыг үе шаттайгаар зохион байгууллаа. 7, 8 дугаар сард сумдын Байгаль хамгаалагч, Байгаль орчны байцаагч, Засаг дарга нарт чиглэл өгч шалгалтыг хийлгэсэн, 09, 10 дугаар сард МХГазар, Цагдаагийн газар, Тагнуулын хэлтэстэй хамтран Сайнцагаан сумын улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу байнгын пост ажиллуулж, Баянжаргалан, Говь-Угтаал сум /хууль бус ан ихээр гардаг тарваганы тархац бүхий орон нутгийн хамгаалалттай газар/-д гэнэтийн шалгалтыг хийж, гарсан зөрчил, хууль зөрчсөн этгээдэд арга хэмжээ авах талаар анхан шатны баримт бүрдүүлэн МХГазарт шилжүүлэн хууль зөрчсөн этгээдэд захиргааны арга хэмжээ авсан. Хураагдсан тарваганы арьс, мах зэргийг устгалд оруулах арга хэмжээг авсан. Тус аймгийн хувьд хууль бусаар тарвага, цагаан зээр, шар үнэг, хярс агнах зөрчил гардаг. Дорноговь, Говьсүмбэр аймгаас ирж, зөрчил гаргах тохиолдол нэмэгдэж байгаагаас гадна уул уурхайн ААНэгжээс мөн зөрчил илэрсэн.

Байгаль хамгаалагчдын хариуцсан газар нутгийн мэдээлэл

№	Сумын нэр	Байгаль хамгаалагчийн овог, нэр	Ажилл асан жил	Хариуцдаг газрын нэр	Хариуцсан талбай га
1	Дэлгэрцогт	Пүрэв Батсайхан	19	Бага газрын чулууны уул, сүм хөх бүрд орчмын байгаль хамгаалагч	59830
2	Дэлгэрхангай	Цэдэндамба Өлзийбат	8,7	Дэлгэрхангай уул орчмын байгаль хамгаалагч	173400
3	Өлзийт	Нэрхүү Гомборагчаа	8,7	Загий ус орчмын байгаль хамгаалагч	171800
4	Баянжаргалан	Төмөр-Ухна Баярсайхан	8	Аргын хад, Хүрэн дух, Эрээн орчмын байгаль хамгаалагч	181400
5	Гурвансайхан	Нацаг Ганхуяг	7,2	Уул-Гурвансайхан орчмын байгаль хамгаалагч	146600
6	Сайнцагаан	Отгонцэрэн Баттөмөр	6,9	Суман хайрхан, Тогоогийн рашаан орчмын байгаль хамгаалагч	186540
7	Өлзийт	Батбуян Бадрах	5,9	Дэл уул, Цагаан суварга орчмын байгаль хамгаалагч	186300
				Хөнжлийн уул	28800
8	Сайхан-Овоо	Болд Гантулга	1,5	Онги гол, Хийдийн уул орчмын байгаль хамгаалагч	173400
9	Эрдэнэдалай	Болд Бат-Эрдэнэ	1	Цагаан овоо, үнстийн хийд, Эрдэнэдалай сум орчмын байгаль хамгаалагч	735101

Байгаль орчин, аялал жуулчлалын газар

